НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 15 өдөр Дугаар А/1304 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.3.3 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.3 дахь заалтыг тус тус заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн камерын дэд бүтцийг судлан камерын хяналтын нэгдсэн төв байгуулах арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахад шаардагдах ажлын даалгавар бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч
Ажлын хэсгийн дэд ахлагч:	Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга
Гишүүд:	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга;
	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;
	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн дарга;
	Тагнуулын ерөнхий газрын Нийслэл дэх газрын тасгийн дарга (зөвшилцсөнөөр);
	Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газрын дарга, (зөвшилцсөнөөр);
	Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн Техник ашиглалтын хэлтсийн дарга, (зөвшилцсөнөөр);
	Тээврийн цагдаагийн албаны Мэдээлэл технологи, холбооны хэлтсийн дарга, (зөвшилцсөнөөр);

1110205679

Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын дэд бөгөөд Захиргааны удирдлагын газрын дарга (зөвшилцсөнөөр);

Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨТҮГ-н дарга;

"Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ Мэдээллийн технологи, техник ашиглалтын хэлтсийн дарга;

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн;

Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын Дэд бүтэц, техникийн хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын дарга;

Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар Төсөл хөтөлбөр, зохицуулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

2.Дээрх ажлын хэсгийн явц үр дүнг 12 дугаар сарын 15-ны өдөр тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэг (О.Номинчимэг)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР